

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 17

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлөөс 2025 оны жилийн үйл ажиллагааны дүнгээр гүйцэтгэсэн ажлын товч тайланг танилцуулж байна.

Нэг. Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалга:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд жилийн дүнгээр салбар зөвлөлөөс 7 удаа гүйцэтгэх 43 албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5-аас доошгүй хоног байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зар”-ыг нээлттэй байршуулсан.

Хүснэгт 1

№	Зар эхэлсэн, дууссан огноо	Орон тоо		
		удирдах	гүйцэтгэх	албан тушаалын нэр
1	2025.02.18 2025.02.23	-	7	хуулийн мэргэжилтэн-1; үндсэн хөрөнгө, бараа материал хариуцсан мэргэжилтэн-1; ХБГ-хяналтын улсын байцаагч-2; мэргэжилтэн-1; ЗБГ-хяналтын улсын байцаагч-2.
2	2025.05.01 2025.05.06	-	3	МТХ-мэргэжилтэн-2; ХБГ-мэргэжилтэн-1.
3	2025.05.21 2025.05.27	-	8	үндсэн хөрөнгө, бараа материал хариуцсан мэргэжилтэн-1; ӨБГ-хяналтын улсын байцаагч-1; ББГ-хяналтын улсын байцаагч-1; ХБГ-хяналтын улсын байцаагч-3; ЗБГ-хяналтын улсын байцаагч-2.
4	2025.06.06 2025.06.12	-	8	МТХ-ахлах мэргэжилтэн-1, мэргэжилтэн-1; ӨБГ-ахлах мэргэжилтэн-1; ХБГ-хяналтын улсын байцаагч-2; мэргэжилтэн-1; ЗБГ-хяналтын улсын байцаагч-2.
5	2025.06.12 2025.16.18	-	3	ГХСХАХ-ахлах мэргэжилтэн-1; ББГ-ахлах мэргэжилтэн-1; ЗБГ, Сүхбаатар аймаг дахь хэлтэс-хяналтын улсын байцаагч-1.
6	2025.12.08 2025.12.13	-	11	МТХ-мэргэжилтэн-2; ӨБГ-хяналтын улсын байцаагч-1; ХБГ-хяналтын улсын байцаагч-5, мэргэжилтэн-1; ЗБГ-хяналтын улсын байцаагч-2
7	2025.12.11 2025.12.16	-	3	ДоАГ-хяналтын улсын байцаагч-1; ББГ-ахлах мэргэжилтэн-1; ЗБГ, Сүхбаатар аймаг дахь хэлтэс-хяналтын улсын байцаагч-1.
ДҮН		0	43	

Дээрх зарын дагуу 21 иргэн shalgalt@immigration.gov.mn цахим хаягаар шилжин ажиллах хүсэлт ирүүлснээс Захиргаа, удирдлагын газарт хуулийн мэргэжилтний 1, Санхүү, хангалт үйлчилгээний газарт үндсэн хөрөнгө, бараа материал хариуцсан мэргэжилтний 1, Мэдээллийн технологийн хэлтэст сүлжээ хариуцсан мэргэжилтний 1, Баруун бүс дэх газарт хяналтын улсын байцаагчийн 1, Зүүн бүс дэх газарт хяналтын улсын байцаагийн 1, нийт 5 албан тушаалын сул орон тоог төрийн бусад байгууллагад ажиллаж байгаа, Төрийн албаны тухай хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан төрийн жинхэнэ албан хаагчдаас нөхсөн.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд салбар зөвлөлийн 02, 07, 08, 13, 14 дүгээр тогтоолоор байгуулсан сонгон шалгаруулалт зохион байгуулах тусгай шалгалтын комиссын хурлаар төрийн жинхэнэ албан хаагчдаас нөхөгдөөгүй 28 албан тушаалын сул орон тооны захиалгыг салбар зөвлөлийн 5 удаагийн албан бичгээр болон se-admin.csc.gov.mn цахим системд ирүүлсэн захиалгыг хянаж, илгээсэн.

Хүснэгт 2

№	Албан бичгийн огноо, дугаар	Орон тоо		
		удирдах	гүйцэтгэх	албан тушаалын нэр
1	2025.02.25 №01	-	6	Үндсэн хөрөнгө, бараа материал хариуцсан мэргэжилтэн-1; ХБГ-хяналтын улсын байцаагч-2; мэргэжилтэн-1; ЗБГ-хяналтын улсын байцаагч-2.
2	2025.05.12 №02	-	3	МТХ-ахлах мэргэжилтэн-1, мэргэжилтэн-1; ХБГ-мэргэжилтэн-1.
3	2025.06.03 №03	-	6	ӨБГ-хяналтын улсын байцаагч-1; ХБГ-хяналтын улсын байцаагч-3; ЗБГ-хяналтын улсын байцаагч-2.
4	2025.06.16 №04	-	10	МТХ-мэргэжилтэн-2; ӨБГ-хяналтын улсын байцаагч-1; ХБГ-хяналтын улсын байцаагч-5, мэргэжилтэн-1; ЗБГ-хяналтын улсын байцаагч-1
5	2025.12.15 №05	-	3	ДоАГ-хяналтын улсын байцаагч-1; ББГ-ахлах мэргэжилтэн-1; ЗБГ, Сүхбаатар аймаг дахь хэлтэс-хяналтын улсын байцаагч-1.
ДҮН		0	28	

Хоёр. Албан тушаалын тусгай шалгалт:

Төрийн тусгай гүйцэтгэх 14 албан тушаалын сул орон тоо нөхөх 3 удаагийн тусгай шалгалт зохион байгуулахаас 06 дугаар сарын 03-ны өдрийн мэдээллийн технологийн мэргэжилтэн, өгөгдлийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд бүртгүүлсэн 2 иргэн мэргэжлийн индекс таараагүй тул зохион байгуулаагүй, 1 шалгалтын хугацаа болоогүй.

Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудсаар нээлттэй зарлуулсан 14 сул орон тооноос 5 буюу 35.7 хувь нөхөгдөөгүй, 42.8 хувь буюу 6 орон тоог нөхөх тусгай шалгалтын хугацаа болоогүй.

Тусгай шалгалтад тэнцсэн иргэдийн 2 буюу 66.6 хувийг төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэний нөөц, 1 буюу 33.3 хувь нь 2024 оны төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй иргэн байна.

Хүснэгт 3

№	Огноо	тоо		сул орон тоог		Тайлбар
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	Нөхсөн	Нөхөөгүй	
1	2025.04.29	-	6	3	3	Босго оноо хүрээгүй 2, бүртгүүлэх хүсэлт ирээгүй 1
2	2025.06.03		2	-	2	Шаардлага хангасан иргэн бүртгүүлээгүй-2
3	2025.06.26		6			Хугацаа хойшилсон
4	2025.07.07		7			Хугацаа хойшилсон

Салбар зөвлөлийн 02 дугаар сарын 24-ний өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулсан тусгай шалгалтын комиссын дүгнэлтийг үндэслэн Хойд бүс дэх газарт 2, Зүүн бүс дэх газарт 1, нийт 3 хяналтын улсын байцаагчийг салбар зөвлөлийн 04, 05, 06 дугаар тогтоолоор тус тус нэр дэвшүүлж, тухайн албан тушаалд томилсон.

Тусгай шалгалтад тэнцээгүй 3, мэргэжлийн индекс таарахгүй үндэслэлээр нэр дэвшүүлээгүй, шалгалтад оруулаагүй иргэдийн баримт бичгийг тухай бүр салбар зөвлөлөөс хянаж, баталгаажуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 06 дугаар сарын 23-ны өдрийн ХЭГ/1760 албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу байгууллагын орон тоо нэмэгдүүлэхтэй холбоотой шийдвэр гаргаагүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгож, төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн үйлчилгээний ангиллын 1 албан хаагчийн болон сул орон тоонд нөхөн томилгоо хийгээгүй, Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан төрийн тусгай албаны гүйцэтгэх 13 албан тушаалын сул орон тооны 2 удаагийн тусгай шалгалтыг байгууллагын даргын 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/1187 албан бичгээр санал хүргүүлж, хойшлуулсан.

Албан ажлын зайлшгүй шаардлагаар хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан тушаалын сул орон тоог нөхөх зорилгоор салбар зөвлөлийн 12 дугаар сарын 12-ны өдрийн 13, 12 дугаар сарын 16-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулсан тусгай шалгалтын комисс байгуулж, нийт 13 төрийн тусгай гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нээлттэй зарлуулж, сонгон шалгаруулалтыг ирэх оны 01 дүгээр сарын 08, 12-ны өдрүүдэд зохион байгуулахаар Төрийн албаны зөвлөлийн se-admin.csc.gov.mn цахим системд захиалгыг баталгаажуулсан.

Тайлант хугацаанд сонгон шалгаруулалтын бүртгэл, шалгалтын явц, дүнд холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй.

Гурав. Бусад үйл ажиллагаа:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем”-ийг хөгжүүлж, 4271 байгууллагыг хамарсан, нийт 228820 албан хаагчийн мэдээлэл бүхий их өгөгдлийн суурийг бий болгосон бөгөөд энэ оны 01 дүгээр сарын 31-ний өдөр болсон цахим системийн танилцуулах уулзалтад оролцож, шинээр хөгжүүлсэн зарим модуль, дэд системүүдийн шинэчлэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

- Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо” цахим системд шинэчлэлт хийгдсэнтэй холбогдуулан төрийн албан хаагч бүр системд байгаа өөрийн мэдээлэлтэй танилцах, засварлах хүсэлт илгээх боломжтой болсонтой холбогдуулан нийт албан хаагчид www.csc.gov.mn цахим хуудасны “Төрийн албан хаагчийн портал” цэсэд танилт нэвтрэлтийн ДАН системээр нэвтрэн орж, өөрийн мэдээлэлтэй танилцах, засварлах шаардлагатай мэдээллийн хүсэлтийг илгээх, засварлуулах, баталгаажуулах тухай Захиргаа, удирдлагын газрын даргын 03 дугаар сарын 07-ны өдрийн 02/29 дотоод албан бичгээр төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд чиглэл хүргүүлсэн.
- Байгууллагын бүтэц, орон тооны мэдээлэл, төрийн тусгай удирдах, гүйцэтгэх албан тушаалын 252 албан тушаалд хамаарах 76 албан тушаалын тодорхойлолт, төрийн үйлчилгээний мэргэжлийн болон туслах 64 албан тушаалд хамаарах 20 ажлын байрны тодорхойлолтыг “Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо” цахим системд хүний нөөцийн мэргэжилтнүүдийн оруулсныг салбар зөвлөлөөс нэг бүрчлэн хянаж, баталгаажуулсан.
- Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 02 дугаар тушаалаар яам, агентлагийн дэргэдэх салбар зөвлөлтэй хамтран Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах зорилгоор 21 аймгийн 330 сумдад ажиллахаар шийдвэрлэсний дагуу байгууллагаас 2 албан хаагчийг 2, 3 дугаар сард ээлжийн хуваариар албан томилолтоор ажиллуулсан.

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийг төлөөлөн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн 02 дугаар сарын 06-18-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан, Баянмөнх, Галшар, Баянхутаг, Хэрлэн, Мөрөн, Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн, Булган, Сэргэлэн сумдад, салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн 03 дугаар сарын 17-31-ний өдрүүдэд Ховд аймгийн Дарви, Мөст, Цэцэг, Говь-Алтай аймгийн Тонхил, Дарви, Төгрөг, Бугат, Шарга, Баян-Уул сумдад албан томилолтоор тус тус ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 82 дугаар зарлигаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Монгол Улсын Төрийн албаны төв байгууллага-Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ой, “Төрийн албаны өдөр”-ийг тохиолдуулан 07 дугаар сарын 02-ны өдөр салбар зөвлөлөөс зохион байгуулсан төрийн тусгай гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтад тэнцсэн, туршилтаар ажиллуулах хугацаа дуусгавар болсон төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн нийт 11 албан хаагчийг төв болон Дорноговь аймаг дахь газар, Баруун болон Хойд бүс дэх газарт нэгэн зэрэг төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүллээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 08 дугаар сарын 06-ны өдрийн ХЭГ/2129 албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу төрийн тусгай албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтны 2024 оны эхний болон сүүлийн хагас, 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлан, үнэлгээний хуудсыг харьяалах нэгж, албан хаагч тус бүрээр нэгтгэн www.immigration.gov.mn цахим хуудасны “хүний нөөц”-“төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ” цэсэд нээлттэй байршуулсан бөгөөд 08 дугаар сарын 20-ны өдрийн 01/1491 албан бичгээр хариуг хүргүүлсэн.

Засгийн газрын 2025 оны “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” 600 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын 1.7-д “төрийн албан тушаалд анх томилогдсон өдрөөс эхлэн төрийн албан хаагчид хувийн хэрэг нээж, мэдээллийг төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн бүртгэлд бүрэн гүйцэд, үнэн зөв оруулна” гэж заасан зохицуулалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд хяналт хийх ажлыг 10 дугаар сарын 15-20-ны өдрүүдэд хилийн боомт, орон нутаг дахь 6 газар, 1 хэлтсийн цахим системийн хөтлөлтөд хяналт тавих ажлыг дараах чиглэлээр хийж гүйцэтгэлээ.

- Харьяа нэгжийн бүтэц, дотоод нэгж, ажлын байрыг зөв үүсгэсэн эсэх;
- Албан хаагчийн үндсэн мэдээллийг (12 төрөл) үнэн зөв, бүрэн оруулсан эсэх;
- Албан хаагч бүр мэдээлэлтэй танилцаж, баталгаажуулалт хийсэн эсэх мэдээлэлд хяналт тавьж, албан хаагч тус бүрээр нягтлан шалгаж, засварлах шаардлагатай болон албан хаагчдыг мэдээлэлтэй танилцуулж, баталгаажуулах ажлын гүйцэтгэл, үр дүнг нэгж тус бүрээр нэгтгэсэн.

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системийн баяжилт, албан хаагчдын хувийн хэргийн баталгаажилт 12 дугаар сарын 17-ны байдлаар 89.2 хувьтай байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврын 1.2, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай” 123 дугаар тушаалын дагуу Засгийн газрын агентлаг, харьяа байгууллагуудын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгжид чиг үүргийн шинжилгээ хийх ажилд дэмжлэг үзүүлэх Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгууллагын

даргын 12 дугаар сарын 12-ны өдрийн А/613 дугаар тушаалаар байгуулж, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад хамрагдаад байна.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн чиглэл, загварын дагуу байгууллагын бүтэц, зохион байгуулалт, нэгж, албан тушаалын орон тоо, албан тушаалын болон ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн судалгааг нэгтгэж, заасан хугацаанд буюу 12 дугаар сарын 12-ны өдөр хүлээлгэн өгсөн. Дээрх чиг үүргийн шинжилгээ нь нийтлэг чиг үүрэг хэрэгжүүлдэг төвийн 4 нэгж (Захиргаа, удирдлагын газар, Санхүү, хангалт үйлчилгээний газар, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс)-ийн 58 албан тушаалд мандатын шинжилгээ, RACI матриц болон Function-Structure matrix аргачлалаар хийгдэх юм.

Байгууллагын хүний нөөцөд дараах төрлийн судалгаа, мэдээлэлд баяжилт, хөдөлгөөн тухай бүр хийж, салбарын яам болон байгууллагын эрх бүхий албан тушаалтныг мэдээллээр хангаж хэвшсэн.

- төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн нийт албан хаагчдын дэлгэрэнгүй excel судалгаа;
- төрийн тусгай албан хаагчдын хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны судалгаа;
- төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн нийт албан хаагчдын ажилласан жилийн excel судалгаа;
- олговортой, олговоргүй чөлөөний excel бүртгэл, судалгаа;
- төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн нийт албан хаагчдын сургууль, боловсрол, мэргэшсэн байдлын нэгдсэн excel судалгаа;
- төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн нийт албан хаагчдын гадаад сургалтад хамрагдсан талаарх нэгдсэн excel судалгаа;
- төрийн албан хаагчдын цахим хувийн хэрэг;
- төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн нийт албан хаагчдын аж байдлын дэлгэрэнгүй excel судалгаа;
- албан хаагчдын орон байрны нөхцөл байдлын excel судалгаа.

Байгууллагын төв болон хилийн боомт, орон нутаг дахь бүтцийн нэгжүүдийн хэмжээнд Төрийн албаны хууль тогтоомж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага зөрчсөн томилгоо байгууллагын хэмжээнд байхгүй.

Тайлант хугацаанд (2025.01.02-12.17) Төрийн албаны зөвлөлийн холбогдох газарт дараах судалгаа, мэдээллийг заасан хугацаанд бүрэн хүргүүлсэн.

- 1.Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний судалгаа 2 удаа;
- 2.Албан үүрэг түр орлон гүйцэтгэгчийн судалгаа 2 удаа;
- 3.Засгийн газрын 2025 оны 24 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн тайлан 1 удаа;
- 4.Сонгон шалгаруулалтын захиалга цуцлах тухай 01/1187 албан бичиг;
- 5.Төрийн тусгай албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтны болон төрийн үйлчилгээний ангиллын албан хаагчдын “төрийн алба хаасан нэг жилийг нэг жил

гурав сар ажилласанд нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системд оруулах хүсэлт 01/1536 албан бичгээр;

6.Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн ашиглалт, мэдээллийн үнэн зөв байдал, төрийн албан хаагчийн мэдээлэл баталгаажуулалтын явцад хяналт тавих зорилгоор харьяа байгууллага болох хилийн боомт, орон нутаг дахь 6 газар, 1 хэлтсийн мэдээллийг хянах, баталгаажуулах эрх авах хүсэлтийг 02/1986 албан бичгээр;

7.Төрийн албаны зөвлөлийн 2025 оны “Төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн” 03 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг 01/2235 албан бичгээр.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ